



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

**Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах
төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган
ажиллах тухай**

Монгол улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3, 34.2.4 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/804 дүгээр захирамж, Багахангай дүүргийн Засаг даргын А/152 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Дүүргийн нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн гамшгийн үед хариу арга хэмжээг зохион байгуулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөө, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган байгууллагын бэлэн байдлыг хангаж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ажилчдад даалгах нь

2.1 Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бэлэн байдлыг хангах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг штабын дарга (Б.Бат-Эрдэнэ)-д

2.2 Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдал, хүнс, эд зүйлсийн нөөцийг бүрдүүлж ажиллахыг нярав (Б.Энхцэцэг)-д

2.3 Бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд зарцуулагдах төсөв, санхүүжилтийг холбогдох зардлаас тухай бүр шийдвэрлэж ажиллахыг нягтлан бодогч (Б.Батжаргал)-д

2.4 Эмч, эмнэлгийн ажилчдыг сургаж бэлтгэх, шаардлагатай үед дайчлан ажиллуулах эмнэлгийн тусгай мэргэжилтэнүүдийн судалгааг гаргах, ажилчдын ажил үүргийг хуваарь зохион байгуулалтыг тухай бүр хийж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Г.Гантуяа)-д

2.5 Халдвараар өвчлөх эрсдлээс урьдчилан сэргийдлэх эм бэлдмэлийн бэлтгэх бэлэн байдал нөөцийг бүрдүүлж ажиллахыг эм найруулагч (Д.Дашдулам)-д

2.5 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг их эмч (Ч.Баасанноров), ахлах сувилагч (О.Удвал) нарт


3. Тушаалын хэрэгжилтэнд хяналта тавьж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
4/45 тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Б.Бат-Эрдэнэ

Гэмтлийн эмч

Гишүүд:

Ч.Баасанноров

их эмч

О.Удвал

Ахлах сувилагч

Н.Батцэцэг

Лаборант

Х.Далайбаяр

Сувилагч

Д.Дашдулам

Сувилагч

Нарийн бичиг

Б.Энхцэцэг

Нярав